

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр

Дугаар: 25/001

Улаанбаатар хот

ТАЙЛАН, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2025 оны 4 сарын 30-ны өдрийн тооллогын комиссын 25/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бизнес төлөвлөгөөг хавсралтаар батлан зөвшөөрсүгэй.
3. Нэмж хувьцаа гаргах, өөрчлөн байгуулах нөхцөл бүрдсэн үед үнэт цаасны танилцуулга болон холбогдох дүгнэлтүүдийг батлахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр

Дугаар: 25/002

Улаанбаатар хот

**КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ,
НЭМЖ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62.1.3, 18, 20, 32.5 заалтууд, 2025 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтьер Лэнд Групп” ХК нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх, хувьцааныхаа төвлөрлийг сааруулах зорилгоор 10 тэрбум төгрөг хүртлэх үнийн дүн бүхий энгийн хувьцаа нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, хувьцааг хуваах эсвэл нэрлэсэн үнийг буулгах, компанийг нэгтгэх зэрэг өөрчлөн байгуулах ажлуудыг хийж гүйцэтгэсүгэй.
3. Дээрх арга хэмжээг авч хувьцаа нэмж гаргах тоо ширхэг, үнийг тогтоон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан арга хэмжээ авч ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр

Дугаар: 25/003

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх заалт, 2025 оны 4-р сарын 30 – ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 10 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүнд тохирох энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК болон Санхүүгийн Зохицуулах Хороо зөвшөөрсний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 10 тэрбум хүртэлх төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.
3. Хуулиар зөвшөөрсөн, тусгай зөвшөөрөл шаардагдахгүй үйл ажиллагаануудыг нэмэх, холбогдох тогтоолыг гаргах эрхийг ТУЗ-д олгосугай.
4. Уг тогтоолтой холбоотой арга хэмжээг авч ажиллахыг компанийн шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр

Дугаар: 25/004

Улаанбаатар хот

**ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА
ХУДАЛДАН АВАХ ЭРХ ЭДЛҮҮЛЭХ ЭСЭХ
ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 38-р зүйл, 2025 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн нэмж гаргаж буй хувьцааг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг одоогийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр

Дугаар: 25/005

Улаанбаатар хот

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлүүд 2025 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийг өөрчлөн байгуулах, нэмж гаргах нэмэлт хувьцааг төрийн эрх бүхий байгууллага зөвшөөрсний дараа нэмэлт хувьцаа гаргах шийдвэртэй санал нийлэхгүй байгаа эсхүл хуралд оролцож санал өгөөгүй хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг тухайн үед нь хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
2. Хувьцаагаа эргүүлэн Компанид зарах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлэн худалдан авах журмыг Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс шийдвэр гарсны дараа боловсруулан хувьцаа эзэмшигчдэд танилцуулсугай.
3. Компани хувьцааг буцаан худалдан авсны дараа төлбөрийн чадвартай үлдэх ёстой гэдгийг санан буцаан худалдан авах үнийг тогтоон энэхүү ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр

Дугаар: 25/006

Улаанбаатар хот

**“МОРЬТ ИМПЕКС” ХХК-ТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭГ
ДҮГНЭХ, ШААРДЛАГАТАЙ АРГА ХЭМЖЭЭГ АВАХ**

Компанийн тухайн хуулийн 62-р зүйлийн 62.1.3 дах заалт, 2025 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани болон анхны үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул сонгино усны цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээг сунгасан гэрээний хугацаа дуусгавар болсон, уг гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс уг гэрээг дахин нягтлан судалж, шаардлагатай арга хэмжээг аван нэмэлт өөрчлөлт оруулан гэрээг шинэчлэн байгуулсугай.
2. Шинэчилсэн гэрээг хавсралтын дагуу баталсугай.
3. Анхны үүсгэн байгуулагч нартай гэрээ байгуулан гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах тал дээр идэвхи чармайлт гарган ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 30 өдөр

Дугаар: 25/007

Улаанбаатар хот

**НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭРИЙГ
ТАЙЛАГНАХ НЬ:**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2025 оны 4-р сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай болон түүний үндэслэл тайлбарыг хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сар 30 өдөр

Дугаар: 25/008

Улаанбаатар хот

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ЗАРДЛЫН ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13 дахь заалт, 2025 оны 4-р сарын 30 –ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтинер Лэнд Групп” ХК-ийн 2025 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны төсөв, гишүүдийн цалин, урамшуулалыг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан төсвийн дагуу ажиллахыг эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сар 30 өдөр

Дугаар: 25/009

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 дах заалт, 2025 оны 4-р сарын 30 – ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 25/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

Ердийн гишүүн

- | | |
|-------------------------|------------------|
| 1. Талипов Камолиддин | 7 454 576 ширхэг |
| 2. Дугарсүрэн Батсайхан | 7 454 576 ширхэг |
| 3. Раднаабазар Отгонбат | 7 454 576 ширхэг |
| 4. Тохтасынов Толон | 7 454 576 ширхэг |
| 5. Оргодол Амартүвшин | 7 454 576 ширхэг |
| 6. Хасанов Эльёр | 7 454 576 ширхэг |

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

Хараат бус гишүүн

- | | |
|---------------------------|------------------|
| 1. Умарова Саодат | 7 454 576 ширхэг |
| 2. Ховдашхан Мухаметгалим | 7 454 576 ширхэг |
| 3. Али Дилдора | 7 454 576 ширхэг |

3. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Р.ОТГОНБАТ